



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот албан даалгавар, Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Байгууллагын хэмжээнд дотоод хяналт, шалгалт явуулах үүрэг бүхий "Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Д.Жаргалцэцэг
Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: О.Мягмартогтох
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн


Ч.Болор-Эрдэнэ
Олон улсын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2. Дээр дурдсан Зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, нэгтгэн гаргах тайлан, мэдээллийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, удирдах дээд байгууллагын тушаал шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт, Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын тайлан, мэдээллийг нэгтгэн удирдлагад танилцуулан холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэх, ажилтнуудын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний улирал, хагас, бүтэн жилийн биелэлтийг тухай бүр дүгнэх ажлыг тус тус зохион байгуулахыг Зөвлөлийн дарга /Д.Жаргалцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Далайн захиргааны даргын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТҮВШИНТӨР

000000054